



# СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№213 /422/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.11.28

Цаг үе, үйл явдал

## ЗХЖШ-ЫН НЭГДҮГЭЭР ОРЛОГЧ ДАРГААР ХУРАНДАА Ж.ӨСӨХБАЯР ТОМИЛОГДЛОО



Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар хурандаа Ж.Өсөхбаярыг Зэвсэгт хүчний Жанжин штабын нэгдүгээр орлогч даргаар томилсон тухай зарлигийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын Төрийн цэргийн байгууллагын асуудал хариуцсан ахлах референт хурандаа Т.Буянбат уншиж сонордуулав. Үүний дараа Монгол Улсын Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх бэлтгэл дэслэгч генерал Ц.Тогоо уг зарлигийг Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга бригадын генерал С.Ганбямбад гардуулан өглөө.

Энэ үеэр Монгол Улсын Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх бэлтгэл дэслэгч генерал Ц.Тогоо хэлсэн үгэндээ "Зэвсэгт хүчний Жанжин штабын нэгдүгээр орлогч даргаар томилогдож буй хурандаа Ж.Өсөхбаяр нь төрийн албанд 30 жил ажилласан, цэргийн гурван шатны сургууль, академийг дүүргэсэн, цэргийн ухааны магистр юм. Тэрээр Зэвсэгт хүчний 256 дугаар ангид салааны захирагчаас батальоны захирагчийн орлогч, штабын даргаар томилогдон ажиллаж, Зэвсэгт хүчний 327 болон 167 дугаар

ангийн захирагч, Зэвсэгт хүчний Хяналт шинжилгээ-үнэлгээний газрын даргаар ажилласан тул энэхүү өндөр хариуцлагатай албан тушаалын бүхий л шаардлага, шалгуурыг бүрэн хангаж байна. Мөн Зэвсэгт хүчний марш тактик, тусгай бэлтгэлийн аварга салаа шалгаруулах болон оны мэргэжлийн аварга офицер шалгаруулах тэмцээнээс олон удаа медаль хүртсэн тэргүүний офицер юм. Хурандаа Ж.Өсөхбаяр 2008 онд "Иракийн эрх чөлөө" ажиллагааны 10 дугаар ээлжийн цэргийн багийн сургалтын офицероор, мөн ИБНАУ-д явагдсан "Шийдвэртэй дэмжлэг" олон улсын цэргийн ажиллагаанд Монгол Улсын Зэвсэгт хүчний 6 дугаар ээлжийн цэргийн багийн захирагчаар үүрэг гүйцэтгэсэн шилдэг офицер гэдгийг Та бүхэн сайн мэдэж байгаа. Ингээд ЗХЖШ-ын дарга, удирдлагын саналыг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх зарлиг буулгаж энэхүү өндөр хариуцлагатай албанд томиллоо" гэдгийг онцлоод шинэ албанд нь амжилт ерөөсөн юм. Мөн тэр бээр Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын зөвлөлийн гишүүдэд хандан "Нэн шинэ

үед Зэвсэгт хүчний Жанжин штабын удирдлага томилогдон ажиллаж байна. Та бид 1990 оноос Батлан хамгаалах тогтолцоо, хууль эрх зүйн үндсийг бүрдүүлж, энхийг дэмжих ажиллагаанд оролцож эхэлснээр Зэвсэгт хүчний нэр хүнд эх орондоо төдийгүй олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн. Цаашид та бүхэн мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчнийг төлөвшүүлж, хөгжүүлэхийн тулд шинэ зорилт, бодлогыг дэвшүүлэн бүтээлчээр хөдөлмөрлөх учиртай. Иймд цэргээ хайрлах ухаанд суралцах, үүнийг хэрэгжүүлэхийн төлөө тэдэнд итгэл өгөх, хайрлах, ажлыг нь дэмжих, зарчимч шаардлага тавих, эргээд тэдний итгэл, дэмжлэгийг нь авах хэрэгтэй. Иймд шинэ үеийн залуусын зорилго, тэмүүллийг дэмжиж, асар их зүйлийг уншиж, судалж, өөрийн үйл ажиллагаандаа бүтээлчээр хэрэгжүүлэх шаардлага бий. Та бүхэн үлдэх мөртэй, хийсэн ажилтай, хэлэх үгтэй, эргээд уулзах нүүртэй байхын тулд шинэ зоримог шийдвэрийг гаргаж, нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн бүтээлч ажлуудыг хэрэгжүүлэх хэрэгтэй" гэдгийг зөвлөж, үүрэг болгов.

Хурандаа Б.ОТГОНБАЯР

## БНТУ-ЫН ЭЛЧИН САЙДЫГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАВ



Монгол Улсын Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга бригадын генерал С.Ганбямба Бүгд Найрамдах Турк Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд эрхэмсэг ноён Зафер Атеш, Батлан хамгаалахын атташе хурандаа Өзгүр Назын Унсал нарыг 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр хүлээн авч уулзав.

Уг уулзалтаар хоёр орны цаашдын Батлан хамгаалах, цэргийн хамтын ажиллагааны талаар санал солилцлоо. Мөн энэ үеэр Бүгд Найрамдах Турк Улс "Хааны эрэлд-2023" энхийг дэмжих ажиллагааны олон улсын сургуульд Тусгай хүчний салааг анх удаа оролцуулна гэдгээ мэдэгдэв.

Хошууч Б.СЕРГЕЙ

### ЦАГ АГААР

#### УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-27	-35


#### ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
37	25

### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3.336	3,441
EUR	3,570	3,590
CNY	474	477
RUB	53.90	54.20
JPY	24.70	25
KRW	2.57	2.60

### ЗУРХАЙ



2022.11.28 /ДАВАА ГАРАГ/  
БИЛГИЙН ТООЛЛЫН 5

**ӨВЛИЙН ТЭРГҮҮН ЦАГААГЧИН  
ГАХАЙ САР  
ДӨРВӨН НОГООН МЭНГЭТЭЙ  
ХӨХӨГЧИН ТАХИА ӨДӨР**

#### Үс засуулбал:

**Эд,мал арвижна**  
**Наран ургах, шингэх:**  
**08.16-17.04**  
**Барилдлага:**  
**Идэр**  
**Шүтэн барилдлага:**  
**Тийн мэдэхүй**

Тухайн өдөр нохой, хонь жилтнээ аливаа үйлийг хийхэд зөрөг сайн. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Эл өдөр баяр баясгалангийн хурим үйлдэх, шинэ гэр барих, хувцас өмсөх, чимэг зүүх, бүжиг наадам үүсгэхэд сайн, эм засал хийлгэх, авшиг авах, бэрийн үйл, дайсныг дарахад болон хуран чуулах, үс угаахад сайн. Зүүн нүд татвал хувцас олдох, баруун нүд татвал тэмцэл болох, баруун чих хангинавал сайн, зүүн нь хангинавал өчүүхэн нэгнийг үзэх, тагнай загатнах, бие татвал үзэсгэлэн болох, хөлийн шөрмөс татвал үг, асуулт болно.

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

#### Тохиолдол

Нийт: 646,257,489

#### Эдгэрсэн

Нийт: 624,822,146

#### Нас барсан

Нийт: 6,636,525

## АГААРЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧИЙГ УГТАН АВЛАА



Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч хурандаа Т.Ганбат Япон Улсын Өөрийгөө Хамгаалах Агаарын хүчний командлагч генерал Изуцү Шунзигийн урилгаар 11 дүгээр сарын 23-28-ны өдрүүдэд Япон Улсад албан ёсны айлчлал хийж байна.

Япон Улсын Батлан хамгаалахын дэд сайд Жиро Кимура, Агаарын цэргийн командлагч хурандаа Т.Ганбатыг халуун дотноор угтан хүлээн авч хэлсэн үгэндээ “Энэхүү уулзалт нь цаашдын Япон-Монголын Агаарын цэргийн хүчний хамтын ажиллагаанд ихээхэн ач холбогдолтой уулзалт юм” хэмээн онцлон тэмдэглэсэн юм.

Дээрх уулзалтын дараа Агаарын цэргийн командлагч хурандаа Т.Ганбатыг Япон Улсын Өөрийгөө Хамгаалах Агаарын хүчний командлагч генерал Изуцү Шунзи Агаарын цэргийн Няакури

бааздаа хүлээн авч уулзлаа.

Уулзалтаар талууд Монгол Улсын Зэвсэгт хүчний Агаарын цэрэг, Япон Улсын Өөрийгөө хамгаалах Агаарын хүчин хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх санамж бичигт гарын үсэг зурав.

Дараагийн өдөр Япон Улсын, Баруун хэсгийн өөрийгөө хамгаалах Агаарын хүчний командлагч дэслэгч генерал Нагумо Кеничиги, хурандаа Т. Ганбатыг хүлээн авч уулзахын зэрэгцээ агаарын цэргийн Касуга болон Сефуриама бааздаа урьж, талууд өөрсдийн санал бодлоо солилцсон юм.

АГААРЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛ

## ЦЭРГИЙН ТАНГАРАГ ӨРГӨХ ЁСЛОЛЫН АЖИЛЛАГАА...



Монгол Улс Анхдугаар Үндсэн хуулиа баталж, Бүгд Найрамдах Монгол Улсаа тунхагласны 98 жилийн ойн өдрийг тохиолдуулан Хувьсгал тэмцлийн ахмад зүтгэлтэн хурандаа О.Сэрдариин нэрэмжит Цэргийн гавьяаны улаан тугийн одонт Зэвсэгт хүчний 015 дугаар ангид 2022 оны хоёрдугаар ээлжээр татагдан ирсэн дайчид эх орондоо үнэнчийн баталгаа болсон цэргийн тангаргаа өргөлөө.

Тус арга хэмжээнд ЗХЖШ-ын орлогч дарга хурандаа Т.Галбадрах, МТГ-ын дарга бригадын генерал М.Мөнхбаяр болон дайчдын ар гэрийн төлөөлөл оролцсон юм.

Энэ үеэр ЗХЖШ-ын МТГ-

ын дарга бригадын генерал М.Мөнхбаяр хэлсэн үгэндээ “цэргийн алба гэдэг хүнийг эх оронч, тэсвэр хатуужилтай болгон төлөвшүүлдэг, хамгийн бахархалтай сайхан алба хэмээн онцлоод 101 жилийн түүхтэй ангийнхаа нэр хүндийг өндөрт өргөж явхийг дайчин эрчүүддээ захисан билээ.

Үргэлжлүүлэн хүндэт зочид төлөөлөгч болон ар гэрийн төлөөлөл хугацаат цэргийн алба хаагчдын бэлтгэсэн жагсаал, гардан тулаан, цэрэгжлийн гимнастик болон урлагийн үзүүлэх тоглолтыг үзэж сонирхсон юм.

Ахлах дэслэгч Д.ДАВААЖАРГАЛ



СУРГАЛТ

## ЦЭРГИЙН ТАНГАРГАА ӨРГӨЖ ЭХ ОРНЫ ХҮҮ БОЛЛОО



Цэргийн гавьяаны одонт Зэвсэгт хүчний 110 дугаар ангид 2022 онд хугацаат цэргийн албанд татагдан ирсэн дайчдын тангаргийн баярыг ЗХЖШ-ын дарга болон ангийн захирагчийн тушаалын дагуу энэ сарын 26-ны өдөр морь цагт ёслол төгөлдөр зохион байгууллаа.

Баярын арга хэмжээнд Улсын их хурлын гишүүн Д.Батлут, Орхон, Булган аймгийн Засаг дарга болон албаны хүмүүс, хугацаат цэргийн алба хаагчдын ар гэрийн төлөөлөл, ангийн нийт бие бүрэлдэхүүн оролцлоо.

Энэ үеэр хүрэлцэн ирсэн зочид төлөөлөгч, хугацаат

цэргийн алба хаагчдын ар гэрийн төлөөлөлд зориулан зэвсэг, инженерийн үзэсгэлэн дэлгэгдсэний зэрэгцээ хугацаат цэргийн алба хаагчид урлагийн номер, жагсаал, гардан тулаан, цэрэгжлийн гимнастикийн үзүүлэх тоглолтоо үзэгч олонд өргөн барьсан юм.

Тангаргаг өргөх ёслолын ажиллагаа өндөрлөсний дараагаар батлан хамгаалах салбартаа он удаан жил, үр бүтээлтэй ажилласан зарим алба хаагчдыг батлан хамгаалах салбарын болон орон нутгийн шагналаар шагнаж урамшууллаа.

Ахмад Т.МӨНХ-ЭРДЭНЭ

## МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ №27

УНШИХ, БИЧИХ ДАДЛАГА

Өмнөх 25, 26 дугаар хичээлээр бид МА, ЛА үсгийн тухай үзсэн. Одоо тэрхүү МА, ЛА үсэг болон үндсэн 7 эгшиг оролцсон, уншихад хялбар, нэг юм уу хоёрхон үеэс бүтсэн, бичлэг дуудлага нь өнөөгийнхтэй бараг таардаг хялбар жишээ үгсийг унших, бичих дасгал дадлага хийцгээе. Зөв уншаад, хичээнгүй сайхан бичиж, кириллээр хөрвүүлээрэй.

Дармал, бичмэл тигээр:

